



ТӨРИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 2020 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”- т “Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн хэрэгжилтэд тавих хяналтыг боловсронгуй болгох хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийн хэрэгжилтэд тавих хяналтыг боловсронгуй болгох зорилгоор Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

1.2.Практик шаардлага:

Монгол Улсын Их Хурлаас 1995 оны 3 дугаар сарын 27-ны өдөр Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг баталсан. 2003 онд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг шинэчлэн баталж, салбарын сайд тус бүрийн дэргэд байсан улсын хяналтын албаны 13 агентлаг, нэгжийг татан буулгаж, төрийн хяналт шалгалтын нэгдмэл тогтолцоог бий болгосон.

Хүчин төгөлдөр үйлчилж буй Төрийн хяналт шалгалтын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд уг нэмэлт, өөрчлөлтөөс 4 нь бусад хуулийн шинэчлэлтэй дагалдаж, 2006 онд орон нутгийн мэргэжлийн хяналтын газрын даргыг томилохтой холбоотой, 2010 онд хяналт шалгалтын зарчим, төрөл, түүнийг хэрэгжүүлэх журам, хяналт шалгалтын объектын эрсдэлийн түвшинг үнелэх, шинжилгээнд дээж авах зэрэг нэмэлт, өөрчлөлтууд

оруулсан байдаг.

Төрийн хяналт шалгалтын улмаас хүнд суртал нэмэгдэж, бизнес эрхлэгчдэд дарамт учирч байна гэсэн ойлголт олон нийтийн дунд түгээмэл байгаа нь олон удаагийн судалгаа, тэдгээрээс гарсан дүгнэлтээр гарсан байдаг. Иймээс хяналт шалгалтын үйл ажиллагааг хүний эрх, эрх чөлөөг дээдлэх, сайн засаглалын үндсэн зарчмыг баримтлах, хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн хэм хэмжээг сэргээн тогтоох, хариуцлагатай, ил тод болгох чиглэлээр боловсронгуй болгох нь зүйтэй. Мөн төрийн байгууллага, албан тушаалтнаас хуулийг хэрэгжүүлэхгүй эс үйлдэхүй гаргах, хуулийг тэгш бус байдлаар хэрэгжүүлэх, эсхүл эрх мэдлээ хэтрүүлэх явдалд хөндлөнгийн байгууллагын хяналтыг бий болгох, үүнтэй холбогдуулан энэхүү хяналтыг хэрэгжүүлэх байгууллагын статус, эрх хэмжээг тодорхой болгох шаардлагатай байдаг. Иймд хуулийг шинэчлэн боловсруулах дараах хэрэгцээ шаардлага байна гэж үзэж байна.

Хяналт шалгалтын байгууллагаас аль салбарын хүрээнд хяналт шалгалт хийх, шалгалтын дунд авах арга хэмжээний зохицуулалт тодорхойгүй байгаа бөгөөд тус үйл ажиллагааг Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хүчингүй болгосон Захиргааны хариуцлагын тухай хуулийг үндэслэн баталсан Засгийн газрын 2003 оны 37 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын мэргэжлийн хяналтын албаны нийтлэг дүрэм”-ийн хүрээнд зохицуулж хэрэгжүүлж байна. Энэ нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан хяналт шалгалтыг хуульд заасан үндэслэлийн дагуу явуулах зарчимд нийцэхгүй байна.

Түүнчлэн хяналт шалгалтын харилцаан дахь төрийн бусад байгууллага, иргэн, хуулийн этгээдийн чиг үүргийг тодорхой болгох, түүнчлэн эдгээр этгээдээс мэргэжлийн хяналтын байгууллагатай харилцах харилцааг нарийвчлан тусгах шаардлагатай. Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан төрийн хяналт шалгалтын талаарх Засгийн газар, яам, агентлаг, Засаг даргын бүрэн эрхийн талаар заасан зохицуулалтууд нь Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн зохицуулалттай давхацсан байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг үндэслэн хийсэн удаа дараагийн хяналт шалгалтаар хууль бус үйл ажиллагаа явуулдаггүй, эрсдэлтгүй, эсхүл эрсдэл багатай болох нь тогтоогдсон хуулийн этгээдэд хийх хяналт шалгалтыг цөөрүүлэх, давтамжийг багасгах зэрэг төрийн ажлыг хөнгөвчилсөн механизм бий болгох шаардлагатай.

Хяналт шалгалт бол нэг төрлийн процессын үйл ажиллагаа юм. Өөрөөр хэлбэл, төрийн хяналт шалгалт нь өөрийн гэсэн хэлбэртэй, шалгалтыг эхлүүлэх үндэслэл, хэрэгжүүлэх журам, хугацаа, арга, шалгалтын дунд авах арга хэмжээ, түүний биелэлтийг хангах механизм зэргээс бүрдсэн цогц үйл ажиллагаа юм. Гэтэл хяналт шалгалтын хэлбэр, түүнийг хэрэгжүүлэх эдгээр процесс бүрэн хуульчлагдаагүй байна. Эдгээр ажиллагааг Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас дотооддоо баталсан дүрэм, журмаар зохицуулж байгааг хуулиар тодорхой тусган хэрэгжүүлж, хүн, хуулийн этгээдийн эрх, тэдгээрийн үйл ажиллагаанд зөвхөн хуульд заасан үндэслэлээр халдах, хязгаарлах нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарчимд нийцүүлэх нь зүйтэй.

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг хэрэгжүүлж байгаа гол байгууллага нь Мэргэжлийн хяналтын байгууллага байна. Үүний зэрэгцээ мэргэжлийн хяналтын

байгууллагаас бусад байгууллага, албан тушаалтан, тухайлбал, оюуны өмч, гадаадын иргэн харьяат, өрсөлдөөн, хэрэглэгчийн эрхийн асуудал хариуцсан төрийн захиргааны болон цагдаагийн байгууллагын албан хаагчид Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг хэрэглэхээр холбогдох хуулиудад эш татан заасан. Үүнээс гадна хяналт шалгалт хийх харилцааг тусад нь авч үзэж зохицуулсан Банкны тухай, Үнэт цаасны зах зээлийн тухай, Өрсөлдөөний тухай, Гаалийн тухай, Татварын ерөнхий хуулиуд хэрэгжиж байна. Эдгээр хуулиудыг судалж үзэхэд төрийн эрх бүхий байгууллагаас хяналт шалгалт явуулах үндэслэл, журам, хугацааг өөр өөрөөр зохицуулсанаас хуулийн уялдаа холбоо алдагдаж, хууль хэрэглээний хувьд бэрхшээлтэй төдийгүй иргэн, хуулийн этгээдэд ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийг үндэслэн хэрэгжүүлж байгаа Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа болон төрийн хяналт шалгалтын үйл ажиллагааны уялдаа холбоог тодорхой болгох шаардлагатай. Зөрчлийн тухай хуулиар төрийн хяналт шалгалтын хүрээнд шийдвэрлэх боломжтой /заавал шийтгэл оногдуулахгүйгээр/ зарим үйлдлийг зөрчилд хамааруулсан. Ингэснээр төрийн хяналт шалгалтын хүрээнд зөвлөн туслах, сануулах, албан шаардлага өгөх зэргээр зөрчлийг таслан зогсоох арга хэмжээ авах боломж хязгаарлагдмал болсон байна. Энэ нь 2012 оны байдлаар мэргэжлийн хяналтын улсын байцаагчаас 19.992 тохиолдолд холбогдох асуудлаар зөрчил дутагдлыг арилгах чиглэлээр албан шаардлага өгч ажилласан бол 2018 оны байдлаар албан шаардлагын тоо 5.819 болж 3.5 дахин буурсан үзүүлэлтээс харагдаж байна.

Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон салбарын хуулиудад мэргэжлийн хяналтын байгууллагын дарга буюу улсын ерөнхий байцаагчаас өөрийн бүтцийн бус төрийн бусад байгууллагын албан хаагчид улсын байцаагчийн эрх олгох зохицуулалтыг ерөнхий байдлаар тусгаж ирсэн боловч улсын байцаагчийн эрх олгох, түдгэлзүүлэх, цуцлах харилцааны талаарх зохицуулалтын нарийвчлан тусгах шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1 дэх заалтыг үндэслэн 2003 онд батлагдсан Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн зохицуулалтын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хуулийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор хуулийн төслийг дараах агуулгаар өргөжүүлж, хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төсөл 7 бүлэгтэй байхаар боловсруулах бөгөөд дараах асуудлыг тусгана.

Нэгдүгээр бүлэгт буюу нийтлэг үндэслэл хэсэгт хуулийн зорилго, төрийн хяналт шалгалтын тогтолцоо, хүрээ, зарчим, нэр томъёоны тодорхойлолт, хяналт шалгалтын зорилгыг тусгана.

Хоёрдугаар бүлэгт хяналт шалгалтын үйл ажиллагааны нийтлэг зохицуулалт болох хяналт шалгалтын төрөл, хэлбэр, арга, эрх бүхий байгууллагуудаас шалгалтыг эхлүүлэх, хэрэгжүүлэх нийтлэг зохицуулалт, шалгалтын хугацаа, шалгалтын үр дүнд авах арга хэмжээний талаар нарийвчилсан журмыг тусгана.

Хяналт шалгалтыг тандалт судалгаа, хяналт шинжилгээ, зөвлөн туслах үйлчилгээ, шалгалт гэсэн хэлбэрээр хэрэгжүүлэхээр зохицуулалтыг тусгана.

Гуравдугаар бүлэгт хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий албан тушаалтан болох улсын байцаагчийн эрх олгох, түдгэлзүүлэх, цуцлах, улсын байцаагчийн бүрэн эрх, гаргах шийдвэрийн төрөл, түүнд гомдол гаргах журам, шийдвэрийн биелэлүүлэх арга журам зэргийг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт хяналт шалгалтын үйл ажиллагааны явцад шалгуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эдлэх эрх, хүлээх үүргийг тусгайлан тусгана. Мөн төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаанд олон нийтийн хяналтын оролцоо, дэмжлэг болон дотоод хяналтын талаарх зохицуулалтыг бий болгоно.

Тавдугаар бүлэгт мэргэжлийн хяналтын байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, мэргэжлийн хяналтын байгууллагаас хэрэгжүүлэх хяналт шалгалтын хүрээ, хязгаарыг тодорхой болгож, хяналт шалгалтын цахим мэдээллийн сан, мэргэжлийн хяналтын улсын байцаагчид тавигдах шаардлага, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа зэргийг тусгана.

Зургадугаар бүлэгт мэргэжлийн хяналтын байгууллагаас төрийн бусад байгууллага буюу Засгийн газар, яам, агентлагтай, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргатай хэрхэн харилцах, ажлын уялдааг хангах зэрэг зохицуулалтыг тусгана.

Долдугаар бүлэгт хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг шинэчлэн баталснаар нэг талаас хүний эрх, эрх чөлөөг хангах, хуулийг биелүүлэх, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, төрийн үүргийг биелүүлэх, нөгөө талаас хяналт шалгалтын ажиллагаан дахь иргэн, хуулийн этгээдийн эдлэх эрх, хүлээх үүрэг, оролцооны зарчим тодорхой болох юм. Энэ нь хяналт шалгалтын хүнд суртлыг багасгах, үр нөлөөг дээшлүүлэх, хамрах хүрээг тодорхой болгох зэрэг зорилт хэрэгжих эрх зүйн үндэс бүрдэнэ.

Төрийн хяналт шалгалт хэрэгжүүлэх байгууллагуудаас хяналт шалгалт хийхдээ энэхүү хуулийн ерөнхий зарчмыг мөрдлөг болгох, тусгайлсан хуулиа хэрэглэхдээ Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг удирдлага болгодог эрх зүйн тогтолцоон бүрдүүлнэ.

Хяналт шалгалтын харилцаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн эдлэх эрх, хүлээх үүргийг хуульчилснаар тухайн этгээд өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаас гадна төрийн хяналт шалгалтын байгууллагын хууль ёсны шийдвэрийг биелүүлэх замаар хүний эрх, нийтийн ашиг сонирхол хамгаалагдах нөхцөл бүрдэнэ.

Хяналт шалгалтын байгууллагыг хэрэгжүүлэх зөвлөн туслах, тандан судлах, хянан шинжлэх, баталгаажуулах зэрэг хяналт шалгалтын бусад хэлбэрийг тогтоосноор хяналт шалгалтын байгууллага иргэдэд илүү ойр байж, тэдэнд үйлчилгээ үзүүлэх, туслах, дэмжих чиг үүргийг хэрэгжүүлдэг болно.

Хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, зохих арга хэмжээ авах, хариуцлага хүлээлгэхэд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хоорондын уялдааг хангаснаар хяналт шалгалтын явцад илэрсэн алдаа дутагдалтай холбоотойгоор

хяналт шалгалтын байгууллагаас авах арга хэмжээ тодорхой болох, иргэн, хуулийн этгээдэд эерэг үр дагавар бий болох нөхцөл бүрдэнэ.

Хуулийн төсөл батлагдан гарснаар бизнес эрхлэгчид болон иргэнд хяналт шалгалтын улмаас учирч буй дарамтыг хөнгөвчлөн, тэдгээрт мэргэжил, арга зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлдэг, хууль зөрчихөөс урьдчилан сэргийлдэг, гаргасан зөрчлийг арилгуулах, иргэн, хуулийн этгээдтэй хуулийн хүрээнд хамтран ажилладаг механизм бий болно.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хууль тогтоомжийн тухай

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай нийцүүлэн боловсруулна. Хуулийн төсөлтэй холбогдуулан Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Нийгмийн даатгалын тухай, Нийгмийн халамжийн тухай, Цөмийн энергийн тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Өрсөлдөөний тухай, Ашигт малтмалын тухай, Зар сурталчилгааны тухай, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай, Таримал ургамлын үр, сортын тухай, Ургамал хамгааллын тухай, Хэмжил зүйн тухай, Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай, Барилгын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Өрсөлдөөний тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай, Харилцаа холбооны тухай, Автотээврийн тухай, Усан замын тээврийн тухай, Иргэний нисэхийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Төрийн хяналт шалгалтын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг боловсруулна.

---оо---